

ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн даатгалын улсын байцаагчид
мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх,
зэргийн нэмэгдэл олгох журмын төсөл
боловсруулсан тухай*

Нийгмийн даатгалын тухай хуулийн 26¹ дугаар зүйлийн 3 дах хэсэгт “Нийгмийн даатгалын байцаагч мэргэшлийн зэрэгтэй байна. Мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар тогтооно.” гэж заасны дагуу Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Нийгмийн даатгалын байцаагчийн мэргэшлийн зэргийг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журам”-ыг баталсан.

Дээрх журмын 5 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох дүрмийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.” гэж заасныг үндэслэн нийгмийн даатгалын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох дүрмийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/73 дугаар тушаалаар батлан, хэрэгжүүлж байна.

Энэхүү дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.1-д заасан “Тэргүүлэх” мэргэшлийн зэргийг 8-аас дээш жил ажилласан, улсын байцаагчийн эрхтэй 518 байцаагчид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/06 дугаар тушаалаар олгосон.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тус тус хэлэлцэн баталсан. Дээрх хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 40 дугаар зүйлийн 40.3-т “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан.

Дээрх хуулийн зохицуулалтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, зэргийн нэмэгдэл олгох журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл, танилцуулга боловсруулав.

Өнөөдрийн байдлаар нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 1 480 байцаагч, ажилтан ажиллаж байгаа бөгөөд 8-аас дээш жил ажилласан, улсын байцаагчийн эрхтэй, тэргүүлэх зэргийн шалгуурыг хангасан 518 байцаагч “Тэргүүлэх” мэргэшлийн зэрэгтэй ажиллаж байна.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ